



ДУНДГОВЬ АЙМАГ  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/33

Мандалговь

Эзэмшил газрын тодорхой хэсгийн  
зориулалтыг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3"г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дах заалт, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3.1.5 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Авишиг-Эвий” ХХК (3430901)-ны Мандал багийн нутаг дэвсгэрт хүнсний ногоо, мод тариалах зориулалтаар эзэмшиж байгаа 0.48 га газрын 0.3га газрыг (Тосгон-4-424) Шатахуун түгээх станцын зориулалттай болгон өөрчилж, үлдсэн 0.18га газрын (Тосгон-4-422) зориулалтыг хэвээр үлдээн 10 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгохыг газрын даамал (Л.Мөнхсарнай)-д даалгасугай.

3.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч “Авишиг-Эвий” ХХК-ны захирал (Ж.Адьяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р.МӨНХТОГТОХ